



БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ДЭРГЭДЭХ СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС



БАЯНХОНГОР АЙМГИЙН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН БАЙДАЛ

2017.07
2017.07



ГАРЧИГ

Аргачлалын тайлбар	3-4
Орон нутгийн төсвийн орлого, зарлага	5
Ажиллагсад, ажилгүйчүүд, ажлын байр	5-6
Мөнгө, банк.....	6-7
Үнэ.....	7
Аж үйлдвэр, худалдаа, зочид буудал, зоогийн газар.....	7-8
Хөдөө аж ахуй	8-9
Нийгмийн даатгал, нийгмийн халамж.....	9-10
Эрүүл мэнд.....	10
Гэмт хэрэг.....	11
Цаг уур	11-12

АРГАЧЛАЛЫН ТАЙЛБАР

- **Хөдөлмөр:** Бүртгэлтэй ажилгүй иргэдэд Монгол Улсын хуулиар зөвшөөрөгдсөн хөдөлмөрлөх насны, хөдөлмөр эрхлэх чадвартай, цалин хөлстэй ажил болон хувиараа хөдөлмөр эрхэлдэггүй, тухайн үед ажиллахад бэлэн, цалин хөлстэй ажил идэвхтэй хайж байгаа Хөдөлмөр, халамж, үйлчилгээний газарт бүртгүүлсэн хүмүүс орсон болно.
- **Эрүүл мэнд, Гэмт хэрэг:** Уг салбарын мэдээнүүдийг холбогдох газар, хэлтсүүд нь нэгтгэн гаргаж ирүүлдэг.
 - **1 хүртэлх насны 1000 хүүхдэд ногдох нялхсын эндэгдлийг** 1 хүртэлх насандаа эндсэн хүүхдийн тоог дээрх хугацаанд амьд төрсөн хүүхдийн тоонд харьцуулж тодорхойлдог.
 - **1-5 хүртэлх насны 1000 хүүхдэд ногдох нялхсын эндэгдлийг** 1-5 хүртэлх насандаа эндсэн хүүхдийн тоог дээрх хугацаанд амьд төрсөн хүүхдийн тоонд харьцуулж тодорхойлдог.
- **Гэмт хэрэг:** Аймгийн цагдаагийн газраас захиргааны статистик мэдээгээр нэгтгэн гаргадаг.
- **Эрүүгийн хуульд** эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр заасан, нийгэмд аюултай гэм буруутай үйлдэл, эс үйлдэхүйг гэмт хэрэг гэнэ. Гэмт хэргийн нийгмийн аюулын шинж чанар, хэр хэмжээ, оногдуулж болох ялын хүнд, хөнгөнийг харгалзан гэмт хэргийг хөнгөн, хүндэвтэр, хүнд, онц хүнд гэж ангилна.

Эрүүгийн хууль шинэчлэгдсэнтэй холбогдон гэмт хэргийн нэр төрөл урьдынхаас нилээд өөрчлөгдсөн.

 - Хүний амь бие, эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэгт бусдыг амиа хорлоход хүргэх, иргэдийн эрх чөлөө, эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг болон хүнийг санаатай алах, болгоомжгүйгээс алах хэргийг нэгтгэн оруулсан.
 - Хүүхэд гэр бүл, нийгмийн ёс суртахууны эсрэг гэмт хэрэгт хүчингийн хэргийг оруулсан.
 - Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэгт бусдын эд хөрөнгийг хулгайлах, бусдын эд хөрөнгийг булаах, бусдын эд хөрөнгийг дээрэмдэх, бусдыг эд хөрөнгийг залилан мэхэлж авах, бусдын эд хөрөнгийг завших, үрэгдүүлэх гэмт хэргийг хамруулсан.
 - Байгаль хамгаалах журмын эсрэг гэмт хэрэгт гал түймрийн хэргийг хамруулсан.
 - Нийгмийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэгт танхайн гэмт хэргийг оруулсан.
 - 18 ба түүнээс дээш насны 10000 хүнд ногдох бүртгэгдсэн гэмт хэргийн тоог гаргахдаа нийт бүртгэгдсэн гэмт хэргийн тоог оны эхний 18 ба түүнээс дээш насны хүн амд харьцуулан тооцно.
- **Хэрэглээний үнийн индекс / ХҮИ / гэдэг нь** хэрэглэгчдийн худалдаж авсан бараа үйлчилгээний нэр төрөл, чанар өөрчлөлтгүй тогтвортой байхад үнэ дунджаар хэрхэн өөрчлөгдөж буйг хэмжих үзүүлэлт бөгөөд нийт өрхөөр тооцсон үнийн өөрчлөлтийг харуулна.

- Үндэсний статистикийн хороо нь хэрэглээний үнийн улсын индексийг Улаанбаатар хотын ХҮИ-ээр тооцож байсан аргачлалаа шинэчилж, 2008 оны 1 дүгээр сараас олон улсын нийтлэг арга зүйн дагуу хэрэглээний үнийн улсын индексийг аймаг, нийслэлийн өрхийн 2010 оны хэрэглээний зардлаар жигнэсэн дундаж үзүүлэлтээр тооцох аргачлалд шилжсэн.
- **Мөнгө, банк:** Монгол банк арилжааны банкуудаас мэдээг авч нэгтгэн, банкуудын үндсэн материалын хамт ирүүлдэг.
- **Төрийн санхүү:** Төсвийн орлого, зарлагын мэдээг Олон Улсын Валютын Сангийн стандарт ангиллаар 1995 оны 10-р сараас эхлэн жил бүр гаргаж байна. Аймгийн төсвийн орлого нь аймаг, сумын төсвийн орлогоос бүрдэнэ. Аймгийн төсвийн мэдээг Санхүү, төрийн сангийн хэлтэс үндсэн нэгжүүдээс авч нэгтгэн ирүүлдэг.
- **Хөдөө аж ахуй:** Мал төллөлт, төл бойжилт, мал хорогдлын мэдээг багийн Засаг дарга нар өрхөөс цуглуулж, сумын тамгын газарт нэгтгэн ирүүлдэг.
- **Аж үйлдвэр:** Аж ахуйн нэгжүүдийг эдийн засгийн үйл ажиллагаагаар ангилахдаа НҮБ-ын эдийн засгийн үйл ажиллагааны Олон улсын стандарт ангиллыг мөрдөж байна. Үндсэн нэгжүүд мэдээг ирүүлдэг.

Нийт бүтээгдэхүүний өсөлтийг тооцохдоо: гол нэр төрлийн бүтээгдэхүүнийг 2010 оны зэрэгцүүлэх үнээр үнэлж тодорхойлсон болно.

Борлуулсан бүтээгдэхүүн нь аж ахуйн нэгж, байгууллагын тайлангийн хугацаанд оны үнээр үнэлж, худалдсан буюу гадагш гүйцэтгэсэн ажил, үйлчилгээний хэмжээ юм.

Гол нэр төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл нь тухайн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн биет хэмжээг харуулна.




ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ОРЛОГО, ЗАРЛАГА

2017 оны эхний 07 сарын байдлаар аймгийн төсвийн орлогын дүн 5303.2 сая төгрөг болж, өнгөрсөн оны мөн үеийнхээс 732.3 сая төгрөгөөр буюу 16.0 хувиар өссөн байна. 2017 оны эхний 07 сарын байдлаар нийт орлогын болон татварын орлогын төлөвлөгөөг Баянхонгор, Галуут, Эрдэнэцогт, Жаргалант, Баяновоо, Бөмбөгөр, Баянбулаг, Заг, Жинст, Богд, Баянговь, Баян-өндөр, Баянцагаан, Баацагаан, Бууцагаан сумууд биелүүлсэн байна.

Орлогын төлөвлөгөөний биелэлтийг төрөл дээр нь авч үзвэл: НӨАТ 83,3 сая төгрөг, Агаарын бохирдол /авто/ 13,1 сая төгрөг, Ашигт малтмал 9,9 сая төгрөг, Газрын төлбөр 16,1 сая төгрөг, Бууны татвар 13,6 сая төгрөг, Түгээмэл тархацтай АМАТ 9,8 сая төгрөгөөр тус тус тасарч, бусад нэр төрөлд биелэлээ.

Нийт орлогод ААНБ-н орлогын албан татвар 3,0 хувь, нэмүү өртгийн албан татвар 4,0 хувь, ЦХТА орлого 50,9 хувь, авто тээвэр өөрөө авагч хэрэгслийн татвар 6,5 хувь, хүү торгууль 8,1 хувь, бусад төлбөр хураамж 27,5 хувийг эзэлж байна.




АЖИЛГҮЙДЭЛ, АЖЛЫН БАЙР, АЖИЛЛАГСАД

2017 оны эхний 7 сарын байдлаар аймгийн бүртгэлтэй ажилгүй иргэд 1204 болж, нийт ажилгүй иргэдийн 55.9 хувь эмэгтэйчүүд байна. Бүртгэлтэй ажилгүйчүүдийг насны бүлгээр авч үзвэл 15-44 насныхан 76.4 хувь, 45 дээш насныхан 23.6 хувийг эзэлж байна. Харин боловсролын түвшнээр харвал бүрэн дунд хүртэл боловсролтой 59.4 хувь, тусгай мэргэжлийн болон техникийн боловсролтой 12.3 хувь, дээд, магистар, доктор боловсролтой 26.5 хувийг тус тус эзлэж байна.

Шинэ ажлын байранд нийт 207 иргэн ажиллаж байгаа бөгөөд үүний 30.9 хувь буюу 64 эмэгтэйчүүд байна. Шинэ ажлын байранд ажиллаж байгаа иргэдийг эдийн засгийн салбараар харвал Хөдөө аж ахуйн салбарт 51, Боловсруулах үйлдвэрийн салбарт 44, Уул уурхай, олборлолт 22, Худалдааны салбарт 18, бусад салбаруудад 72 хүнд шинэ ажлын байр гаргаж ажиллаж байна.

Эхний 7 сарын байдлаар нийт 552 ажлын байрны захиалга ирсэн байна. Ажлын байрны захиалгыг эдийн засгийн салбараар үзвэл Төрийн удирдлага, батлан хамгаалах,

албан журмын даатгалд 115, Удирдлагын дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаанд 16, Хөдөө аж ахуйн салбарт 84, бусад салбаруудад 1-44 ажлын байрны захиалга иржээ.




МӨНГӨ ЗЭЭЛ, ХАДГАЛАМЖ

Монгол банкны аймаг дахь салбараас ирүүлсэн мэдээгээр 2017 оны 07 дугаар сарын 30-ны байдлаар арилжааны банкуудаар 2784,8 сая төгрөг эргэлдэж байна.

Оны эхний 7 сарын байдлаар нийт зээлийн өрийн үлдэгдэл 127233,8 сая төгрөг байгаагийн 123446,4 сая.төгрөг нь хэвийн зээл, 2694,2 сая.төгрөг нь анхаарал хандуулах зээл /хугацаа хэтэрсэн/, 2993,1 сая төгрөгийн чанаргүй зээл байна.

Эхний 7 сарын байдлаар иргэдийн хадгаламж 75612,0 сая.төг болжээ. Үүний 20117,0 сая.төг нь хугацаагүй хадгаламж, 55189,7 сая төг нь хугацаатай хадгаламж байна.

Аймгийн банкны салбарын нийт ашиг өссөн дүнгээр 6693,7 сая.төг болжээ.



ХЭРЭГЛЭЭНИЙ ҮНЭ

2017 оны 7 дүгээр сард бараа үйлчилгээний үнэ тариф 2016 оны 12 сарынхаас 6,3 хувиар, өнгөрсөн оны мөн үеийнхээс 4,9 хувиар өсч, өмнөх сарынхаас 0,2 хувиар буурсан байна. Хүнсний бараа ундаа усны бүлгийн дүн 2017 оны 07 дүгээр сард өмнөх сарынхтай харьцуулахад 2.0 хувиар, эм тариа

эмнэлгийн үйлчилгээний бүлгийн дүн 1,8 хувиар, холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээний бүлгийн дүн 0,2 хувиар буурч, согтууруулах ундаа, тамхи, мансууруулах бодисын бүлгийн дүн 0,2 хувиар, хувцас, бөс бараа, гуталын бүлгийн дүн 0,8 хувиар, орон сууц, ус, цахилгаан, хийн болон бусад түлшний бүлгийн дүн 0,4 хувиар, гэр ахуйн тавилга, барааны бүлгийн дүн 0,5 хувиар, тээврийн үйлчилгээний бүлгийн дүн 0,9 хувиар, бусад бараа үйлчилгээний бүлгийн дүн 1,5 хувиар өссөн нь ерөнхий индекс 0.2 хувиар буурахад нөлөөлсөн байна. Тухайлбал: Өмнөх сарынхаас үхрийн мах, хонины мах, ямааны мах, хорхой ааруул, байцаа, лууван зэргийн үнэ 2,3-33,4 хувиар буурсан байна.

Хүнсний гол нэр төрлийн барааны үнийн мэдээгээр Хонины мах, ямааны мах өмнөх оны мөн үеийнхээс 10,0-13,8 хувиар буурч, элсэн чихрийн үнэ 10 хувиар, ноолуурын үнэ 28,9 хувиар, Бензины үнэ 4,7-6,3 хувиар өсчээ.


Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний үнийн мэдээгээр үхрийн шир, адууны дэл, сүүлний үнэ өмнөх оны мөн үеийнхээс 50,0-75,0 хувиар өсчээ.




АЖ ҮЙЛДВЭР

2017 оны эхний 7 сарын байдлаар аж үйлдвэрийн борлуулсан бүтээгдэхүүн 3240,0 сая төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 12,8 хувиар буюу 477,3 сая төгрөгөөр буурсан байна.


Нийт борлуулалтыг салбараар авч үзвэл: Уул уурхай, олборлох аж үйлдвэр 21.8, Боловсруулах аж үйлдвэр 16.3, Цахилгаан, дулаан, уур үйлдвэрлэл 50.7 хувийг тус тус эзэлж байна.



2017 оны эхний 06 сард Худалдааны нийт орлого 11067,1 сая төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеийнхээс 29,8 хувиар өсчээ.



2017 оны эхний 06 сард Зочид буудал, зоогийн газрын нийт орлого 162,0 сая төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеийнхээс 11,5 хувиар буурчээ.



ХӨДӨӨ АЖ АХУЙ

Баянхонгор аймаг эхний 6 сарын байдлаар оны эхний хээлтэгч малын 82,7 хувь буюу 1440,4 мянган толгой эх мал төллөсөн байна. Төллөсөн хээлтэгчийн төрлөөр нь оны эхний хээлтэгчтэй харьцуулвал ингэ 46,1 хувь буюу 7.8 мянган, гүү 64,1 хувь буюу 31,1

мянган, үнээ 72,1 хувь буюу 57,1 мянган, эм хонь 86,5 хувь буюу 458,6 мянган, эм ямаа 83,1 хувь буюу 885,7 мянган толгой тус тус төллөсөн байна.


Нийт 1440,4 мянган хээлтэгч төллөж 1423,9 мянган төл бойжуулсан байна. Бойжуулсан төлийг төрлөөр харвал ботго 7.7 мян, унага 30,6 мян, тугал 56,4 мян, хурга 454,5 мян, ишиг 874,6 мянган толгой байна.

Төл бойжилтийг төрлөөр үзвэл ботго 9.6, Унага 98.7, Тугал 98.9, Хурга 99.3, Ишиг 98.9 хувь нь бойжсон байна.

Сумдаас Богд сум 100.0 хувиар бойжуулсан байна.


бойжсон төл 3%

■ Унага ■ Тугал ■ Ботго ■ Хурга ■ Ишиг



Мөн 6 дугаар сарын 30-ны байдлаар 14.6 мянган тал мал зүй бусаар хорогдсон нь оны эхний нийт малын 0.3 хувийг эзлэж байна. Хорогдолыг төрлөөр нь авч үзвэл адуу 762, үхэр 1366, тэмээ 35, хонь 4238, ямаа 9715 тус тус хорогджээ. Хорогдолын 0.4 хувь буюу 58 толгой том мал өвчнөөр хорогдсон байна.

Мөн нийт хорогдсон малын 19.0 хувь буюу 3062 толгой хээлтэгч мал хорогджээ.



Эхний 6 сарын байдлаар 255.4 га талбайд тариалалт хийсэн байна. Тариалсан талбайг задлаж харвал.

Төмс 152.5 га, Тэжээлийн ургамал 33 га, Хүнсний ногоо 69.9 га-д тус тус тариалжээ.

тариалсан талбай 2017.06 сар






НИЙГМИЙН ДААТГАЛ, НИЙГМИЙН ХАЛАМЖ

Аймгийн Нийгмийн даатгалын сангаас оны эхний 7 сарын байдлаар Өндөр настны тэтгэвэрт 7552 хүнд 14554,9 сая төг, Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тэтгэвэрт 2155 хүнд 3352.7 сая төг, Тэжээгчээ алдсаны тэтгэвэрт 662 хүнд 1122,1 сая төг тус тус олгожээ.

Эдгээр тэтгэвэрүүдийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад өндөр настны тэтгэвэр 304 хүн 1199.8 сая төг, Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тэтгэвэр 195 хүн 592.2 сая төг, Тэжээгчээ алдсаны тэтгэвэр 78.4 сая төгрөгөөр тус тус өсчээ.

Нийгмийн халамжийн сангаас Жирэмсэн болон нярай, хөхүүл хүүхэдтэй эхчүүдийн тэтгэмжид 3018 эхэд 553.1 сая төг, Ахмад настныг асарч буй 910 иргэнд 348.5 сая төг, Хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг асарч буй 412 иргэнд 142.7 сая төг, Бүтэн өнчин хүүхэд үрчлэн өсгөсний тэтгэмжид 68 хүнд 28.7 сая төг, Ахмад настнуудад үзүүлсэн хөнгөлөлт, тусламжид 687 ахмадад 142.0 сая төг, Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үзүүлсэн хөнгөлөлт, тусламжид 329 иргэнд 61.3 сая төг, Нийгмийн халамжийн хөнгөлөлт, нөхцөлт мөнгөн тусламж 1640 хүнд 474.9 сая төг, Алдар цолтой ахмадуудад үзүүлсэн хөнгөлөлт, тусламжид 15 ахмадад 17.3 сая төгрөг тус тус зарцуулсан байна.

Нийгмийн халамжийн сангаас олгосон тэтгэмж өмнөх оны мөн үеэс Жирэмсэн болон нярай, хөхүүл хүүхэдтэй эхчүүдийн тэтгэмж, Ахмад настныг асарч буй иргэнд олгох тэтгэмж, Бүтэн өнчин хүүхэд үрчлэн өсгөсний тэтгэмж, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үзүүлсэн хөнгөлөлт, тусламж, алдар цолтой ахмадуудад үзүүлсэн хөнгөлөлт, тусламж, Ахмад настнуудад үзүүлсэн хөнгөлөлт, тусламжууд өсч, бусад тэтгэмж хөнгөлөлтүүд өмнөх оны мөн үеэс буурчээ.



ЭРҮҮЛ МЭНД

Аймгийн эрүүл мэндийн газрын мэдээгээр оны эхний 7 сарын байдлаар 1109 эх амаржиж 1112 хүүхэд төрсөн байна. Үүнийг өмнөх оны мөн үетэй харьцуулвал амаржсан эх, төрсөн хүүхэд тус бүр 2.7 хувиар буурчээ.

Аймгийн эрүүл мэндийн салбарт нийт 153200 үзлэг хийгдэж 11909 хүн эмчлүүлсэн байна. Мөн салбарын хэмжээнд 9354 түргэн тусламжийн дуудлага ирсний 24.5 хувь буюу 2294 нь алсын дуудлага байжээ.

Эхний 7 сарын байдлаар нийт 257 хүний нас баралт бүртгэгдсэн байна. Үүнээс 1 хүртлэх насны эндэгдэл 20 бүртгэгджээ. Үүнийг өмнөх оны мөн үетэй харьцуулвал 44.5 хувиар буурсан байна.

Мөн тайлант сарын байдлаар халдварт өвчний гаралтаар Хүйтэн, арьсны мөөгөнцөр, Сүрьеэ, халдварт гепатит, ёлом, суулгалт халдварт өвчнүүд өмнөх оны мөн үеэс өсч, бусад халдварт өвчин буурсан байна.



ГЭМТ ХЭРЭГ

2017 оны эхний 7 сарын байдлаар 260 гэмт хэрэг бүртгэгдсэний 137 нь хөнгөн, 96 хүндэвтэр, 24 хүнд, 3 онц хүнд гэмт хэрэг байжээ. Нийт гэмт хэргийг өмнөх оны мөн үетэй харьцуулж үзвэл 18.1 хувиар өсчээ. Ингэж өсхөд голлож хөнгөн, хүнд хэргүүд өссөн нь голлон нөлөөлсөн байна.

Нийт гэмт хэргээс өмчийн хулгайн хэрэг 88 гарсанг задлаж харвал:

- Иргэдийн өмчийн хулгай 50
- Малын хулгай 27

- Тээврийн хэрэглийн хулгай 11 гарсан бөгөөд иргэдийн өмчийн хулгай, тээврийн хэрэгслийн хулгай өмнөх оноос буурсан байна.

Гэмт хэргийн улмаас нийт 128 хүн бэртэж гэмтсэн бол 14 хүн нас барсан байна.

Нийт гэмт хэргийн уламаас 475.7 сая. төгрөгийн хохирол учирсанаас 274.2 сая төгрөгийн хохиролыг нөхөн төлүүлсэн байна. Нийт хохирол өмнөх оны мөн үеэс 11.4 хувиар өсч, нөхөн төлүүлсэн хохирол 9.6 хувиар буурчээ.


Нийт гэмт хэрэгт 260 хүн холбогдогчоор татагдсан байна. Гэмт хэрэг үйлдэхдээ 28 холбогдогч бүлэглэж, 65 холбогдогч согтуу байсан байна.

Аймгийн цагдаагийн газрын мэдээгээр 5418 зөрчил гарсан бөгөөд 1606 шийтгэвэрээр, 3564 торгуулийн хуудасаар торгосон байна.

Эхний 7 сарын байдлаар 988 хүн эрүүлжигдсэн бол 212 хүн баривчлагдсан байна.

Нийт гэмт хэргийн 57,3 хувь буюу 149 гэмт хэрэг нь аймгийн төв буюу Баянхонгор суманд гарсан байна.

Гэмт хэргийн зарим үзүүлэлт



ЦАГ УУР

2017 ОНЫ 07 ДУГААР САРЫН ЦАГ АГААРЫН УРЬДЧИЛСАН МЭДЭЭ

Уур амьсгалын дунджаар агаарын температурын сарын дундаж нь Баян-Өндөр, Шинэжинстийн өмнөд хэсгээр 22-27 градус, Баян-Өндөр, Шинэжинстийн дунд хэсгээр, Баянговь, Баацагааны зүүн, Баянхонгор, Баян-Овоо, Эрдэнэцогт, Өлзийт, Жинст, Богд, Баянлиг сумдын нутгаар 17-21 градус, бусад нутгаар 12-16 градус дулаан байдаг.

Энэ сард агаарын дундаж температур нийт нутгаар уг дунджаас 0.5-1.0 градусаар дулаан байх төлөвтэй. Уур амьсгалын дунджаар Гурванбулаг, Байдраг, Заг, Галуут, Бөмбөгөр, Баян-Овоо, Эрдэнэцогт, Өлзийтийн нутгаар 45-75мм хүртэл бороо ордог бол бусад нутгаар 13,1-44мм бороо ордог. Энэ сард Баян-Өндөр, Шинэжинст, Баянлиг, Баянговийн өмнөд хэсгээр нутгаар дунджаас бага бусад нутгаар дундажийн орчим бороо орох төлөвтэй.

**БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ДЭРГЭДЭХ СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС**